



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН  
ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам,  
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот, 17100  
Утас/Факс: (976-11) 32 79 68  
Цахим хуудас: www.transport.ub.gov.mn

2026.03.24 № 1/437  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН  
ДАРГА Б.УУГАНБАТ ТАНАА**

Тус газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар гарган, хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Г.БИЛГҮҮН

D:\alban khereg\явсан бичиг-2026\alban bichig-A5.docx

1726090155



Нийтийн тээврийн бодлогын газрын даргын  
2026... оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 1/437  
тоот тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН  
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН  
2026 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН МЭДЭЭ

2025 оны 03 дугаар сарын 24

Улаанбаатар хот

Д/д	Тайлан	Хугацаа	
1	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн нэгдсэн системээр бүртгэн шилжүүлсэн нийт өргөдөл, гомдол – 295		
	Шийдвэрлэх шатандаа байгаа - 20		
	Хугацаандаа шийдвэрлэсэн - 275		
	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн - -		
2	Иргэний талд шийдвэрлэсэн - 198	2025.01.02 2025.03.23	
	Боломжгүй тухай хариу өгсөн – 76		
	Бусад – -		
	Шийдвэрлэлт - 93,2%		
3	Хэлтэс, нэгжид хувиарлагдсан өргөдөл, гомдлын тоо:		
	Захиргаа, удирдлагын хэлтэс – 78		
	Тээврийн бодлого, судалгааны хэлтэс – 80		
	Санхүү, аж ахуйн хэлтэс – 13		
	Зорчигч, тээврийн хэлтэс – 12		
	Хяналт шалгалтын хэлтэс – 102		
	Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэс – 3		
	Бүртгэл, техник, технологийн хэлтэс – 4		
Хуулийн хэлтэс- 3			
3	Гомдол – 128		
	Хүсэлт – 136		
	Санал – 25		
	Талархал – 3		
	Зөрчил- 3		
	Мэдэгдэл- 0		
<b>Зөрчлийн тоон үзүүлэлт</b>			
4	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	-	2025.01.02 2025.03.23
5	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	-	
6	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	-	
7	Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	-	
8	Дундаж хоног	6 хоног 2 цаг 35 минут	
9	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-	

• Тус газрын өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн UB ERP нэгдсэн системд 2026 оны 03 дугаар сарын 23-ны байдлаар нийт **295** өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 275, шийдвэрлэх шатандаа байгаа 20 өргөдөл, гомдол байна.

## Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу зохион байгуулан хэрэгжүүлсэн ажлын талаар:

Нийт ирсэн өргөдөл, гомдлын 128 буюу 43.3 хувь “Гомдол” байгаагаас Тээврийн бодлого, судалгааны хэлтэст-31, Хяналт шалгалтын хэлтэст-82, Зорчигч, тээврийн хэлтэст-6, Захиргаа, удирдлагын хэлтэс-0, Бүртгэл, техник, технологийн хэлтэст-1, Санхүү, аж ахуйн хэлтэст-6, Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэст-2, хуулийн хэлтэст-0 гомдол ирсэн байна.


Автобусны жолоочийн үйлчилгээний соёлын тухай-30, Нийтийн тээврийн салбарын үйл ажиллагааны тухай-22, Буудал дээрх автобусны зогсолтын тухай-15, Автобусны цагийн хуваарийн тухай-11, Автобусны буудал, зогсоол шинээр нээх, цэгцлэх тухай-8, Автобусны чиглэл, маршрутын тухай-7, Автобусны буудал нэмэх, буудлын тохижилтын тухай-6, Автобусны жолооч, кондукторын үйлчилгээний соёлын тухай-5, Автобусны жолооч, кондукторын үйлчилгээний соёлын тухай-5, Автобусны карт цэнэглэлтийн тухай-4, Нийтийн тээврийн үйлчилгээний аюулгүй байдал, стандартын тухай-4, Автобусны тоо, чиглэл нэмэх, өөрчлөх тухай-4, Автобусны цэвэрлэгээ, үйлчилгээний тухай-2, Авто зогсоол, төлбөртэй зогсоолын тухай-1, Автобусны карт уншигч төхөөрөмжийн тухай-1, Том оврын тээврийн хэрэгслийн зөрчлийн тухай-1, Цалин, хөлсний тухай-1 тус тус гомдлууд байна.

Гомдол мэдээллийн дагуу Сар шинийн баяр, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр “Мартын-8” зэрэг 3 удаагийн бүх нийтийн баярын өдрүүдээр нийтийн тээврийн хэрэгслийн цагийн хуваарьт өөрчлөлт оруулж ажилласан.

Гомдол мэдээллийн дагуу шинээр нээх, өөрчлөлт оруулсан чиглэлүүд:

1. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсол хоорондын зайг ойртуулж, иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс Нийтийн тээврийн үйлчилгээний Ч:25Б “Нисэх-ТЭЦ-4-3,4 хороолол-Гандан” чиглэлийн замналд “Ирээдүй хотхон” (Урд) (Хойд) зогсоолыг шинээр нэмсэн.

### Ч:24Б “НИСЭХ - ТЭЦ 4 – 3,4-Р ХОРООЛОЛ – ГАНДАН”



2. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс Хан-Уул дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай Ривер гарден (хойд) зогсоолыг шинээр нээж Ч:63 “Хан хиллс хотхон-Ривер гарден-МУБИС-Ард кино театр” чиглэлийн замналд 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр өөрчлөлт оруулав.

Нийтийн тээврийн газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт

## Ч:63 “ХАН ХИЛЛС ХОТХОН – РИВЕР ГАРДЕН – МУБИС – АРД КИНО ТЕАТР”



3. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс хоёр шинэ чиглэлийн үйлчилгээг нэвтрүүлээд байна. Тухайн хоёр шинэ чиглэл нь

Ч:67 “Морингийн даваа-Нисэх”, Ч:10 “Гадна тойруу-Баянмонгол хороолол-ТЭЦ-3” 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн иргэдэд үйлчилж эхэлсэн.



4. 2025-2026 оны хичээлийн жилийн сурагчдын өвлийн амралт эхэлсэнтэй холбоотой сургуулийн автобусны үйлчилгээнд ажилладаг автобусны жолооч, хүүхэд зохицуулагч нарт MNS 6440:2014 Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага, MNS 5012:2021 Нийтийн тээвэр, Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага, UCS 1604B:2022 Хүүхдийн автобусанд тавих ерөнхий шаардлага стандартын мэдлэг, мэдээллийг олгох, бататгах сургалт зохион байгуулагдсан.


Сургуулийн автобусны үйлчилгээ эрхлэгч ОНӨААТҮГ-ууд тус бүрдээ сургалтыг зохион байгуулж нийт 105 жолооч хүүхэд зохицуулагч хамрагдсан.

  
**НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР**  
 14000/Монгол Улс, Улаанбаатар, Дундговь дүүрэг, 23 дугаар хороо, Хонь тууль иргэдийн хороо/байр Орон  
 Утас/Факс: 1070-11-22 79 68  
 Эвэлжүүлэх: www.tvet.gov.mn

МСХАГ 12 № 143  
**СУРГУУЛИЙН АВТОБУСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДАД**

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын өвлийн амралт үргэлжилж байгаатай холбогдуулан сурагчийн автобусны үйлчилгээнд ажиллаж байгаа жолооч, хүүхэд зохицуулагч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын хөдөлгөөнд оролцох болон MNS 6440:2014 Хүүхэд тээвэрлэх автобус, Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага, MNS 5012:2021 Нийтийн тээвэр, Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага стандартын хүрээнд сургалтыг зохион байгуулж тайланг 2026 оны 01 дүгээр сарын 23-ны дотор тус газарт ирүүлнэ үү.


 Нийтийн тээврийн бодлогын газар  
 Удирдлага  
 Дарга  
 Давуанцмыс ОТГОНЖАРГАЛ  
 2026.01.12.15.59



### Сургалтын үйл явцаас

5. Нийтийн тээврийн бодлогын газраас нийтийн тээврийн хэрэгслийн шалгах хуудасны ашиглалт, шинэчлэх хэрэгцээ шаардлагын талаар тус газрын Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ч.Бадамханд, Авто тээврийн хяналтын улсын байцаагч М.Мөнхзул, Хууль тогтоомж судлаач М.Ариунзаяа нар Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын ХАБЭА-н инженер, шалгах механикийн мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулсан. Сургалт 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулагдаж Нийтийн Тээврийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудын 40 ХАБЭА ажилтан инженер хамрагдсан.


**Нийтийн тээврийн бодлогын га**  
 Jan 20

Нийтийн тээврийн бодлогын газраас нийтийн тээврийн хэрэгслийн шалгах хуудасны ашиглалт, шинэчлэх хэрэгцээ шаардлагын талаар тус газрын Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ч.Бадамханд, Авто тээврийн хяналтын улсын байцаагч М.Мөнхзул, Хууль тогтоомж судлаач М.Ариунзаяа нар Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын ХАБЭА-н инженер, шалгах механикийн мэргэжилтнүүдэд мэдээлэл өгч, санал солилцож байна.  
 #нийтийнтээвэр




### Сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг байгууллагын цахим хуудсанд мэдээлэв.

6. Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ-тай хамтран Шинэ жолоочийн сургалтыг 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж 5 ААНБ-ын 19 жолооч хамрагдав.



### Сургалтын үйл явцаас

7. Чингис хаан ОУНБ-ын чиглэлд зорчигч тээвэрлэгч такси үйлчилгээний жолооч нарт зориулсан сургалтыг Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтийн дарга нарын хамтран баталсан Удирдамжийн дагуу 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Нисэхийн гаалийн сургалтын танхимд зохион байгуулагдаж Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт ХХК-ийн ажилчид, таксийн жолооч нийт 92 хүн хамрагдсан.



ЧХОУНБ-ЫН ЧИГЛЭЛД ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭГЧ ТАКСИ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖОЛООЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН УДИРДАМЖ

#### Нэг. Үндэслэл

- 1.1. Автозавчийн тухай хуульд автозавчийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь тээврийн хэрэгслийн ашиглалт, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах жолоочийн мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажирлагааг хангах үүрэгтэй гэж заасан.  
Мөн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч нь үйлчлүүлэгчид аюулгүй найдвартай чанартай үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд үүнийг хангах нэг арга хэмжээ нь жолооч нарт сургалт зохион байгуулах юм.
- 1.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон замын хөдөлгөөний дүрмийн дагуу замын хөдөлгөөнд оролцогч бүр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй бөгөөд тээврийн хэрэгслийн жолооч нь хөдөлгөөний дүрэм, аюулгүй ажиллагааны шаардлагыг чанд мөрдөх ёстой.  
Иймээс зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь жолооч нарт аюулгүй жолоодлого, замын хөдөлгөөний соёл, аслоос урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах шаардлагатай.
- 1.3 Зөрчлийн тухай хуульд автозавчийн болон замын хөдөлгөөний холбогдох хууль тогтоомж дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд хуульчлах харууцлагыг тодорхойлсон байдаг. Тухайлбал, зөвшөөрөлгүй тээврийн үйлчилгээ эрхлэх, тэрбум зөрчих замын хөдөлгөөний дүрэм зөрчих зэрэг зөрчлүүдэд харууцлага ногдуулдаг тул жолооч нарт хууль эрх зүйн мэдлэг олгох, урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах нь чухал аж холбогдолтой.
- 1.4 Такси үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор батлагдсан МNS 5122:2013 "Такси үйлчилгээ Ерөнхий шаардлага" стандартад нь такси үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага, жолоочийн ёс зүй, үйлчилгээний соёл, тээврийн хэрэгслийн техникийн болон ариун цэврийн шаардлагыг тодорхойлсон байдаг.  
Энэхүү стандартыг хэрэгжүүлэх хүрээнд жолооч нарыг мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээний стандартыг мөрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.

**Нийтийн тээврийн бодлогын га...**

2d

"Чингис хаан" ОУНБ-ын чиглэлд зорчигч тээвэрлэгч такси үйлчилгээний жолооч нарт зориулсан сургалтыг Нийтийн тээврийн бодлогын газар, Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс, "Вип такси сервис" ХХК-тай хамтран зохион байгууллаа.

➤ Сургалтад "Нью Улаанбаатар" интернэйшнл эйрпорт" ХХК-ийн ажилчид, таксийн жолооч нийт 92 жолооч хамрагдлаа. ✅ Сургалтаар Нийтийн тээврийн салбарт мөрдөгддөг үндсэн стандартууд, жолооч нарын гаргадаг нийтлэг зөрчил, Замын хөдөлгөөний дүрмийн шинэчилсэн найруулга, ажлын байрны харилцааны сэтгэл зүй гэх мэт олон чухал сэдвээр мэдээлэл өглөө.

<https://www.transport.ub.gov.mn/a/358>  
#нийтийнтээвэр



### Сургалтын үйл явц

8. 2026 оны эхнээс 3024 чиглэлд үйлчилгээнд ажиллаж байгаа их болон дунд багтаамжийн 1173 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж. Давхардсан тоогоор 6348 тээврийн хэрэгсэлд 8461 зорчигчдыг шалгаж, бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлс төлөөгүй зэрэг нийт 14809 зөрчил илрүүлж, зөрчлийг газар дээр нь арилгуулж, 8755 зорчигчийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс татгалзан, зорчуулахгүй буулгаж, 13045 зорчигчийн картанд Easy pay /изи пей/ посын цэнэглэлтээр 373,081,000 мянган төгрөгийн цэнэглэлт хийж ажилласан.

9.2026 оны эхнээс 03 дугаар сарын 23-ны байдлаар 102-Police application –аар Замын хөдөлгөөний удирдлагын төв рүү 2683 автомашины зөрчлийг фото зургаар баримтжуулан ажиллаа. Мөн Автотээврийн хяналтын улсын байцаагч нар 12 зорчигчийн зөрчлийг илрүүлж, 120.000 төгрөгийн шийтгэл ногдуулж ажиллалаа.

10.Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, маршрут, цагийн хуваарь мөрдөлт, баримт бичгийн бүрдэл, гэрээний үүргийн биелэлт, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад хяналт тавин ажиллаа. Зөрчлийг арилгуулах зорилгоор улсын байцаагчийн 1 заалт бүхий 1 албан шаардлага, 78 тээврийн хэрэгсэлд 660 заалт бүхий 39 техникийн дүгнэлт гаргасан.

11.Иргэдээс ирүүлсэн гомдол, хүсэлтийн дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч нар ажиллаж нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 17 аж ахуйн нэгж байгууллага, 76 иргэн, автобусны жолооч нарын гаргасан 99 зөрчилд 11,740,000 сая төгрөгийн торгууль шийтгэврийн хуудсаар тавьж ажиллалаа.

Гомдлын дагуу боломжгүй тухай хариу өгсөн 40, гомдол гаргагчид мэдээлэл өгч иргэн талд шийдвэрлэсэн 78, шийдвэрлэх шатандаа байгаа 9 гомдол байна.

### Иргэдээс ирүүлсэн саналын дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын талаар:

Нийт ирсэн өргөдөл, гомдлоос 25 буюу 8,5 хувь “Санал” байгаа нь Тээврийн бодлого, судалгааны хэлтэст-19, Хяналт шалгалтын хэлтэст-1, Зорчигч, тээврийн хэлтэст-2, Бүртгэл, техник, технологийн хэлтэст-1, Санхүү, аж ахуйн хэлтэст-1, Хуулийн хэлтэст-1 тус тус санал ирсэн байна.


Иргэдээс ирүүлсэн саналын дагуу боломжгүй тухай 8 иргэнд хариу өгч, 13 иргэнтэй санал солилцож иргэн талд шийдвэрлэж, шийдвэрлэх шатанд байгаа 4 санал байна.

### 2018-2026 оны санал, гомдлын харьцуулсан дүн мэдээ



### Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацааны талаар:


#### 2018-2026 оны өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хоног



- Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хоног 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 6 хоног 2 цаг 35 минут байгаа нь нийслэлийн дундаж хоногт багтаан шийдвэрлэж байгаа үзүүлэлттэй байна.

### Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад гаргасан зөрчлийн талаар

2019-2026 оны өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн явцад гаргасан зөрчлийн тоо



- 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил, өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил гараагүй байна.
- Мөн байгууллагын хүний нөөцийн чиглэлээр ирсэн 83 өргөдөл, гомдлыг цаг тухай бүр шийдвэрлэн ажилд авах, чөлөөлөх, чөлөө олгох, тусламж дэмжлэг үзүүлэх чиглэлээр Газрын даргын 75 тушаал гарч өргөдөл, гомдлыг шийдвэрлэн ажиллалаа.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Б.Мандхай*

Б.МАНДХАЙ

МЭДЭЭ ГАРГАСАН:

ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН  
ГОМДОЛ ХАРИУЦСАН АХЛАХ АЖИЛТАН

*С.Билгүүн*

С.БИЛГҮҮН